

Гадаадын иргэн харьяатын газраас мэдэгдэл гаргах нь



世界をつなぐ。未来をつくる。

出入国在留管理庁
Immigration Services Agency

~2026 онд Кумамотод болсон газар хөдлөлтөөс хамааран оршин суухтай холбоотой өргөдөл, хүсэлт хүлээн авах тухай~

2026 (Рэйвагийн 8 он) оны 7 дугаар сар

Энэ удаагийн "2026 оны Кумамотогийн газар хөдлөлт"-ийн нөлөөгөөр хуульд заасан хугацаанд болон тогтоосон журмын дагуу Орон нутгийн Гадаад иргэн харьяатын газарт (Цагаачлалын алба) өргөдөл, хүсэлт гаргах боломжгүй болсон (эсвэл гаргаж чадаагүй) иргэдэд дараах мэдэгдлийг хүргэж байна.

1 Оршин суухтай холбоотой өргөдөл, хүсэлтийг хүлээн авах хугацааны тухай

Гамшигт өртсөний улмаас оршин суух зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд багтаан өргөдөл, хүсэлт гаргаж чадаагүй иргэдийн хувьд, одоогоор тодорхойгүй хугацаанд оршин суух хугацаа нь дууссан тохиолдолд ч тусгайлан авч үзэн холбогдох журмын дагуу шийдвэрлэх тул өөрт хамгийн ойр байрлах Гадаад иргэн харьяатын газарт хандан өргөдөл гаргахтай холбоотой зөвлөгөө авна уу.

2 Оршин суухтай холбоотой өргөдөл, хүсэлтийг хаана гаргах тухай

Гамшгийн улмаас өөрийн үндсэн оршин суугаа газраас өөр газар руу түр нүүсэн эсвэл нүүлгэн шилжүүлэгдсэн иргэд одоо амьдарч газрыг хариуцсан Гадаад иргэн харьяатын газарт өргөдөл, хүсэлт гаргах боломжтой.

Дээрх зохицуулалтын талаар тодруулах зүйл байвал өөрт хамгийн ойр байрлах Орон нутгийн Гадаад иргэн харьяатын (入管) газраас лавлана уу

※Орон нутгийн Гадаад иргэн харьяатын газруудын байршил, холбоо барих мэдээллийг доорх URLхаягаас үзнэ үү.

URL

<https://www.moj.go.jp/isa/about/region/index>